БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

# УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 20 ДУГААР ХОРОО ЭРЧИМ ХҮЧНИЙ ГУДАМЖНЫ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| | | |
|---|---|---|
| 1 | Ерөнхий зүйл | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо Эрчим хүчний гудамжны өргөтгөл, шинэчлэлтийн авто зам, замын байгууламжийн зураг төслийн иж бүрдэл:<br>- Авто замын ажлын зураг /шифр 10/23/<br>- Геодезийн тайлан /Төгс төсөл ХХК/<br>- Геологийн тайлан /Лэнд тест ХХК/<br>- Дулааны шугамын зураг /шифр СЭ.02/24/<br>- Цахилгаан дамжуулах кабель шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам зөөх ажлын зураг-1 /шифр ХМ-2024/15/<br>- Цахилгаан дамжуулах кабель шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам зөөх ажлын зураг-2 /шифр ХМ-2024/15/<br>- Цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг /шифр ВЭ-24/05/<br>- Холбооны худаг сувагчлал, кабел шугамын шилжүүлэг /АБ-А 01/6-24-ГХ/<br>- Борооны усны шугамын ажлын зураг /шифр GS-FP-04/24/<br>- Тайлбар бичиг<br>- Техникийн шаардлага<br>- Төсөв (авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээ)<br>Авто зам, замын байгууламжийн зураг төслийг “Жи Ар Си” ХХК боловсруулсан. |
| 2 | Барилгын талбайн үзүүлэлт | - Одоо байгаа трасс нь асфальтан зам бөгөөд өргөтгөл шинэчлэлт хийгдэнэ. Авто замын нийт урт 5.913 км болно. Авто замын зураг нь 3 хэсгээс бүрдэнэ.<br>- 1-р хэсэг 2.176 км<br>- 2-р хэсэг 0.199 км<br>- 3-р хэсэг 3.538 км |
| 3 | Ажлын цар хүрээ | - Эрх бүхий байгууллагаар боловсруулсан магадлалаар батлагдсан авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг |

төслийн дагуу зам барилгын ажлыг гүйцэтгэнэ.

- Одоо байгаа авто зам нь 8-9 м-ийн өргөн асфальтбетон хучилттай авто зам болно.
- Өргөтгөл шинэчлэлт хийгдэх авто зам нь 4 эгнээ, 4x3.5 м өргөн зорчих хэсэгтэй, 2x0.8 м өргөн ногоон байгууламж, 2x1.5 м өргөн явган хүний зам болон 2x0.5 м хөвөөтэй байхаар төлөвлөгдсөн байна.

Тус өргөтгөл, шинэчлэлт хийгдэх авто зам нь 3 хэсгээс бүрдэнэ.

**Эхний шатанд 3-р хэсэг буюу 3.538 км авто зам, замын байгууламжийн барилгын ажил,**

**Инженерийн шугам сүлжээний ажил /цахилгаан, гэрэлтүүлэг, цахилгаан дамжуулах агаарын шугам, холбооны шугам, дулааны шугам, борооны ус зайлуулах шугам/-ууд нийт замын уртад хийгдэнэ.**

Авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг үзэх.

ПК0+00-ПК35+37.7 /3.538 км/ Нарийвчилсан зураг үзэх

Авто замын хучилтын хийц: Төрөл 1:

Одоо байгаа хучилтан дээр:

ПК6+20-ПК35+37.7 /2.9177 км/

Нэг маягийн хөндлөн огтлол үзэх

- Өнгө асфальтбетон хучилт - 3 см
- Суурь асфальтбетон хучилт - 4 см
- Тэгшилгээний үе - 3 см

Өргөтгөл хийгдэх хэсэгт:

- Өнгө асфальтбетон хучилт - 3 см
- Суурь асфальтбетон хучилт - 4 см
- Цементээр бэхжүүлсэн суурь -20 см
- Хөлдөлтөөс хамгаалах үе -30 см
- Геотор /суурийн/

Авто замын хучилтын хийц:

Төрөл 2: Одоо байгаа хучилтан дээр: ПК0+00-ПК6+20 /0.62 км/

Нэг маягийн хөндлөн огтлол үзэх

- Өнгө асфальтбетон хучилт - 3 см
- Геотор /хучилтын/
- Суурь асфальтбетон хучилт - 4 см
- Цементээр бэхжүүлсэн суурь - 20 см

Өргөтгөл хийгдэх хэсэгт:

| | | |
|---|---|---|
| | | - Өнгө асфальтбетон хучилт - 3 см<br>- Геотор /хучилтын/<br>- Суурь асфальтбетон хучилт - 4 см<br>- Цементээр бэхжүүлсэн суурь -20 см<br>- Хөлдөлтөөс хамгаалах үе -30 см<br>- Геотор /суурийн/<br><br>Хиймэл байгууламж /одоо байгаа хоолойг буулган шинээр хийх 2.0x4.0x7/ нарийвчилсан зургаас үзэх.<br>*Авто зам, замын байгууламжийн 1-р хэсгийн төсвөөс ажлын тоо хэмжээг авах, Техник, технологийн хяналт зөвлөх үйлчилгээний зардал тооцохгүй.* |
| 4 | Ажлын хил хязгаар | Төсөлд Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж хамаарна. (Ажлын зургаас байршлыг нарийвчлан үзнэ үү.) |
| 5 | Барилгын ажлын зохион байгуулалт | 1. Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журмын дагуу зөвшөөрөл авна.<br>2. Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд гүйцэтгэгч нь ажлын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллана.<br>3. Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах, шинээр хийх ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, дулаан, холбоо, борооны ус зайлуулах, гэрэлтүүлэг гэх мэт.<br>4. Гүйцэтгэгч нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгууллагатай зөвшилцөж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө.<br>5. Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг, тэмдэглэгээ г.м./-ыг бүрэн хангаж ажиллана.<br>6. Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях, төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн засаг даргын албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчтай харилцан зөвшилцөж ажиллана.<br>7. Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид, нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч хүн хүч, машин механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ. |

| | | |
|---|---|---|
| | | 8. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу гүйцэтгэнэ.<br>Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ явганаар зорчиж буй ард иргэдэд саад учруулахгүй байх.<br>Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангах ажиллах, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллалтын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай.<br>НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэнэ.<br>9. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.<br>10. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Заасрын дагуу фото зургаар баталгаажуулаагүй , 7 хоног тутмын тайланд тусгаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар ашиглана.<br>11. Барилгын ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулна. |
| 6 | Бусад | Авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө. |

**ХЯНАСАН:**

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мягмар

**БОЛОВСРУУЛСАН:**

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн Н.Энхтуяа

2024 оны 5... сарын 09-ний өдөр

**Гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан**

| № | Албан тушаал | Ажилтны тоо | Боловсрол мэргэжлийн ур чадвар | Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага |
|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий инженер | 1 | Авто замын инженер /мэргэшсэн/ | 8 болон түүнээс дээш |
| 2 | Авто замын инженер | 1 | Авто замын инженер | 5 болон түүнээс дээш |
| 3 | Гүүрийн инженер | 1 | Гүүрийн инженер | 5 болон түүнээс дээш |
| 4 | Материалын инженер | 1 | Материалын инженер эсвэл авто замын инженер | 3 болон түүнээс дээш |
| 5 | Геодезийн инженер | 1 | Геодезийн инженер эсвэл авто замын инженер | 3 болон түүнээс дээш |
| 6 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан | 1 | (ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх) | 2 болон түүнээс дээш |
| 7 | Цахилгааны инженер | 1 | Цахилгааны инженер | 5 болон түүнээс дээш |

**Гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизм**

| № | Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Тоо ширхэг | Хүчин чадал | "Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих |
|---|---|---|---|---|
| 1 | Экскаватор | 2 | 1.5 м3 дээш | Өөрийн эзэмшил-1, түрээс-1 |
| 2 | Авто ачигч | 2 | 1.25 м3 дээш | Өөрийн эзэмшил-1, түрээс-1 |
| 3 | Ачааны автомашин | 6 | 10 тн дээш | Өөрийн эзэмшил-3, түрээс-3 |
| 4 | Автокран | 1 | 5 тн дээш | Өөрийн болон түрээс |
| 5 | Автогрейдер | 2 | 175 м.ц дээш | Өөрийн эзэмшил-1, түрээс-1 |
| 6 | Усны машин | 1 | 6 тн дээш | Өөрийн эзэмшил |
| 7 | Далангийн индүү | 2 | 13 тн дээш | Өөрийн эзэмшил-1, түрээс-1 |
| 8 | Автогудронатор | 1 | 6000 л | Өөрийн болон түрээс |
| 9 | Асфальтбетон дэвсэгч | 1 | 7-9м | Өөрийн болон түрээс |
| 10 | Хос булт индүү | 1 | 4 тн дээш | Өөрийн болон түрээс |
| 11 | Хийн дугуйт индүү | 1 | 10 тн дээш | Өөрийн болон түрээс |
| 12 | Гөлгөр булт индүү | 1 | 4-8тн | Өөрийн эзэмшил |

**Хянасан:**

НЗХГ-ын ЗБИБХХ-ийн дарга Т.Батбилэг

**Боловсруулсан:**

НЗХГ-ын ЗБИБХХ-ийн хяналтын мэргэжилтэн Д.Төрбилэг